

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 5/03

Мандалговь

Г. Энхтайванг ажилд томилох тухай

Монгол Улсын “Төрийн албаны тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 22.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 05/1343 тоот албан бичиг, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 4.1, 4.2 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Г.Энхтайванг санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчаар 2018 оны 03 сарын 09-ны өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.

2. Г.Энхтайванг ТЗ-6-3 зэрэглэлийн 613669 /Зургаан зуун арван гурван мянга зургаан зуун жаран ёс/ төгрөгөөр цалинжуулахыг нягтлан бодогч /С.Энхтайван/-д зөвшөөрсүгэй.

3. Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дах заалтыг үндэслэн Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг сар бүр үндсэн цалингаас 5 хувиар бодож олгосугай.

4. “Төрийн албаны тухай хууль” –ийн 28 дугаар зүйлийн 28.2.4 дэх заалт, Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 11 тоот албан бичгийг үндэслэн “Дөтгөөр” зэргийн 10 хувийн нэмэгдэл олгож байсанг үргэлжлүүлэн сар бүр үндсэн цалингаас бодож олгосугай.

5. Төсөв, санхүү аудитын холбогдолтой хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хөтөлбөр, арга зүй, Засаг даргын шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Г.Энхтайванд үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ЗОРИГТ